



## БАГА БОЛОВСРОЛЫН БАГШ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАРЬЦУУЛАЛТ, ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ (2000-2021 оны сургалтын төлөвлөгөө)

Г.Бямбатогтох<sup>а</sup>, Ц.Тамир<sup>б</sup>  
<sup>а</sup>МУБИС-Багшийн сургууль;  
<sup>б</sup>МУБИС-Багшийн сургууль

Холбоо барих зохиогч: [Byambatogtokh@msue.edu.mn](mailto:Byambatogtokh@msue.edu.mn) 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

### Хураангуй

Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд мэдээлэл харилцааны технологи асар хурдацтай хөгжиж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин хүмүүсийн сурч боловсрох эрэлт хэрэгцээ эрс нэмэгдэж, сургалт хурдацтай өөрчлөгдөж байна. Энэхүү хувьсал нь боловсролын арга барилыг үндсээр нь өөрчлөхөд түлхэц болж, энгийн агуулга эзэмших чадвараас илүү утга учиртай ур чадварт суурилсан сургалтын туршлага руу шилжсэн. Багш бэлтгэх байгууллагууд эдгээр өөрчлөлтөд хариу арга хэмжээ авч, технологийн дэвшил, хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөр, стандарт, сургалтын арга зүй, сайжруулахад анхаарч ажиллаж байна. Бид сүүлийн 20 жилийн хугацаанд бага боловсролын багш бэлтгэх сургалтын төлөвлөгөө хэрхэн өөрчлөгдөж шинэчлэл хийгдэж байгаад дүн шинжилгээ хийхийг гол зорилго болгосон юм. Бага боловсролын багш бэлтгэх шаардлагад бүтцийн өөрчлөлт гарсан. 2014 оноос өмнөх хөтөлбөрт 134-137 кредит цаг шаардлагатай байсан бол 2014-2021 оны хугацаанд 124-126 кредит болгож өөрчилсөн байна. Цаашид 2025 он гэхэд дэлхий даяар суралцах хоёр тэрбум хүүхэд болох Альфа үеийнхний хэрэгцээг хангахын тулд сургалтын хөтөлбөрийг улам боловсронгуй болгох шаардлагатай.

### Түлхүүр үг

Ерөнхий суурь, багш мэргэжил, мэргэшүүлэх хичээл, дадлага, кредит цаг, харьцуулалт.

### Удиртгал

МУБИС-ийн багш боловсролын талаар баримтлах бодлогод багш бэлтгэх хөтөлбөрийн үнэлгээг 5 жил тутам хийж, хөтөлбөрийг олон улсын түвшинд магадлан итгэмжлэх тогтолцоог бий болгох, зохион байгуулах, сургалтын төлөвлөгөөг хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх шаардлагыг бакалаврын сургалтын албанаас тавьж байгаа. Цаг үе, нийгмээ дагаад 15-20 жил тутамд шинэ

үеийн сурагчид суралцаж байна. Тэдний хүлээлт, ур чадвар, зан төлөв, тухайн үеийн өвөрмөц нөхцөл байдлаас шалтгаалж шинэ сорилттой тулгарах, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөх, ирээдүйд бэлтгэхэд чиглэсэн шинэ хэтийн төлөв, нэн шаардлагатай болсоор байна. Үүнийг дагаад бид бага боловсролын багш бэлтгэх тогтолцоонд өөрчлөлт хийх, багш бэлтгэх сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрөө шинэчлэн сайжруулах хэрэгцээ үүссээр байна.

### **Зорилго, судалгааны арга**

Бага боловсролын багш мэргэжлийн бакалаврын сургалтын төлөвлөгөөг 2000-2021 оны хооронд хэрхэн өөрчлөгдөж, шинэчлэн сайжруулж ирснийг харьцуулан судлах. Судалгааны аргачлал: Баримт материалд дүн шинжилгээ хийх, харьцуулсан судалгааны аргыг сонгосон.

### **Онолын үндэслэл**

Майкл Эппл бөгөөд Паоло Фрейри нар сүүлийн 40 жилийн туршид Америкийн боловсролын байгууллагуудыг ширүүн шүүмжилж, сургуулийн ёс зүйн талаар нэлээд бичсэн байдаг. Сургуулийн хөтөлбөрт шинэчлэл хийх ёстой. Бид юу заах вэ? гэхээс илүү хэн гэсэн ухагдахууныг хөтөлбөр боловсруулагчид анхаарах ёстой гэж үзсэн байна. (Вэсли Нулл. 2011) Сургалтын төлөвлөгөөнд тухайн хичээлийг хэдийд, ямар хугацаанд, хэр хэмжээтэй, судлахыг заасан байдаг бол сургалтын хөтөлбөрт сургалтын агуулга буюу судлах зүйлийн хүрээг тогтоох төдийгүй сургалтыг зохион байгуулах арга, хэлбэр, сургалтын орчинг хөгжүүлэх чиг хандлагыг тодорхойлж, сургалтын үр дүнг яаж хэмжихийг нарийвчлан төлөвлөсөн байдаг. Бид сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт явуулах шаардлагатай. Сургалтын бүтэц, зохион байгуулалт, сургалтыг макро түвшинд хөтлөх бодлогын үндсэн баримт бичиг нь сургалтын төлөвлөгөө юм. Сургалтын төлөвлөгөө боловсруулах гэдэг нь нэгдмэл үйл ажиллагаа. Сургалтын төлөвлөгөөг боловсруулахад: (Нийгмийн эрэлт хэрэгцээн дээр үндэслэн анализ хийнэ, Мэргэжилтний мэдлэг, чадварт анализ хийж ажлын байрны тодорхойлолтыг гаргана, Сургалтын зорилго, зорилтыг тодорхойлж, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, стандартыг боловсруулдаг)

### **Судалгааны үр дүн**

2000-2011 нийт кредитийн харьцаа 130-136 кредит, 2014-2021 онд 124-126 кредит цаг судлахаар тусгажээ. Сургалтын төлөвлөгөөний бүтэц нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх гэсэн чиглэлтэй байсан бол 2014 оноос 4 бүтэцтэй болж багш мэргэжлийн суурь хичээл гэсэн бүтэц нэмэгдсэн байна. 2018 онд (ерөнхий суурь хичээл, багш мэргэжлийн суурь хичээл, мэргэжлийн хичээл) гэсэн 3 бүтэцтэй болгож дахин өөрчилсөн байна.

График 1. Багш, бага боловсролын сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн харьцуулалт



Хүснэгт 1. Ерөнхий суурь хичээлийн заавал судлах хичээлийн харьцуулалт

№	Хичээлүүд	2000	2003	2007	2008	2011	2014	2018	2021
1	Мэдээлэл харилцааны технологи	2	2	3	3	2	2	2	2
2	Англи хэл II	6	6	8	8	8	3	3	3
3	Монгол хэл бичиг, н/зүй						3	3	3
4	Сэтгэлгээний түүх соёл						2	2	
5	Бүтээлч сэтгэлгээ						1	1	
6	Монголчуудын түүх соёл	2	2				3	3	3
7	Биеийн тамир I			2	2	2	1	1	1
8	Биеийн тамир II						2	1	1
9	Гамшгийн менежмент						1	1	1
10	Байгалийн ухаан-2						2	2	2
11	Философи	2	2						3
12	Экологи	2	2						
13	Эрүүл мэндийн боловсрол	2	3						
14	Улс төр, эрх зүй	2	2						
15	Эдийн засаг	2	2						
16	Сайн дурын ажил							2	2
	Нийт кредит	20 кр	20 кр	13 кр	13 кр	12 кр	20 кр	21 кр	21 кр

Дээрх онуудад мэдээлэл харилцааны технологи, англи хэлний хичээлүүд нь заавал судлах хэсэгт тасралтгүй байдлаар тусгагдсан байна. Англи хэлний хичээл 2000-2013 он хүртэл 6-8 кредит байхаар төлөвлөгөөнд тусгаж байсан бол 2014 онд англи хэлний суурь чадвараар шалгалт өгч тэнцсэн тохиолдолд дундаас дээш түвшинд англи хэл II хичээлийг их сургуулийн ахисан түвшинд судлахаар тусгажээ. 2014 оноос хойш сургалтын төлөвлөгөөнд дараах шинэчлэлүүд хийгдсэн байна. Эх хэл, үндэсний соёл, ёс суртахуун, зан заншил, уламжлалаа мэдэж хүндэтгэх, эх

орноороо бахархах, хүрээлэн буй орчноо таних, хайрлан хамгаалах, хүн төрөлхтний хэл, соёлоос суралцах, бие бялдрын хөгжил, хүмүүжил, шинжлэх ухааны мэдлэг, чадварыг цогц байдлаар хөгжүүлэх суурийг хөтөлбөрт илүү тусгаж өгч байсан бол өмнөх онуудад гүн ухаан, эрүүл мэнд, эдийн засаг, улс төр, байгаль экологийн боловсролыг заавал судлахаар оруулж байжээ. 2000-2003 онд заавал судлах кредитийн харьцаа 2014-2021 оны сургалтын төлөвлөгөөний харьцаатай ойролцоо байгаа нь дээрх үзүүлэлтээс харж болохоор байна.

Хүснэгт 2. Ерөнхий суурь хичээлийн сонгон судлах хичээл

№	Хичээлүүд	2000	2003	2007	2008	2011-2013	2014-2017	2018-2020	2021-2022
1	Хүмүүнлэгийн ухаан		6	6	6				
2	Нийгмийн ухаан		6	3	6				
3	Байгалийн ухаан								
Нийт кредит		0	12 кр	9 кр	12 кр	10 кр	4 кр	4 кр	4 кр

2003- 2008 оны үед хичээлийн төрөл нь хүмүүнлэгийн ухаан, нийгмийн ухааны чиглэлээр 3-6 кредит, 2011-2013 онд хичээлийн тоо нэмэгдэж нийт 10 кредит хичээл сонгон судлахаар заажээ. Энэ нь бусад он цагтай харьцуулбал давуу талтай хүмүүнлэг, оюутны хэрэгцээ, сонирхолыг илүү харгалзсан чухал өөрчлөлт байсныг онцлон тэмдэглэж байна. 2014-2021 оны хичээлийн жилд сонгон судлах хичээл багц байдлаар боловсруулагдаж хичээлийн тоо нэмэгдсэн ч нийтдээ 4 кредит сонгох ёстойг заасан байна. (Хүмүүнлэгийн ухааны сонгонд 14 хичээл, нийгмийн ухааны сонгонд 8 төрлийн хичээл, байгалийн ухаанд 3 төрлийн хичээл) тусгасан байна.

Хүснэгт 3. Мэргэжлийн суурь хичээлийн заавал судлах хичээл

№	Хичээлүүд	2000	2007	2008	2011	Хичээлүүд	2014
1	Мэргэжлийн удиртгал		1	1	1		
2	Сэтгэл судлал (ХХСЗ)	6	5	5	5		
3	Сурган хүмүүжүүлэх зүй	8	6	7	6		
4	Монгол хэл заах арга зүй	21	8			Авиа зөв дуудах, Зөв бичих зүй	2
5	Тусгай хэрэгцээт боловсрол		2	2	2		
6	Эрүүл мэнд, заах арга				1		
7	ОЦМХ		7			Үгийн сан	2
8	Хүүхдийн уран зохиол ЗА	6	4			Эхийн найруулга	2
9	Монгол бичиг заах арга	6	3			Аман зохиол	1
10	Анхан шатны математик ЗА	21	8			Олонлог логикийн элемент	2
11	Математик ББО		6			Алгебр, геометрийн элемент	3
12	Сургуулийн математик	4				Рационал тоо, үйлдэл	2
13	Орон нутаг судлал заах арга	4					

14	Хүн ба байгаль, ЗА		3			
15	Хүн ба нийгэм, ЗА		3			
16	Зохион бүтээх хөдөлмөр ЗА	3	3			
17	Дуу хөгжим заах арга	3	3			
18	Дүрслэх урлаг ЗА	3	3			
19	Бие бялдрын боловсрол ЗА	3	3			
20	Ангийн ажил	2	2		1	
	Нийт	90	69	15	15	14

2000-2011 оны сургалтын төлөвлөгөөнд сэтгэл судлал 5-6 кредит, сурган хүмүүжүүлэх арга зүй 6-8 кредит, Тусгай хэрэгцээт боловсрол 2 кредит, Монгол хэл 21 кредит, Математик 21 кредит судлахаар төлөвлөж оруулж байсан бол 2014 оны шинэчлэлээр монгол хэл нийт 6 кредит, математик 7 кредит цагаар төлөвлөж оруулсан байна. Энэ үед “Эх хэл” “Математик”-ийн хичээлүүдийг мэргэжлийн суурь хэмээн үзэж нийт 14 кредит цаг судлахаар оруулсан байна. 2018 онд сургалтын төлөвлөгөөний үндсэн бүтэц өөрчлөгдсөн. 2000 онд мэргэжлийн суурь хичээлд 90 кредит судалдаг байсан бол 2014 онд энэ нь 14 кредит цаг болж эрс өөрчлөлт орсон нь цаг үе, нийгмийн эрэлт хэрэгцээ оюутан төвтэй хандлага, сурах үйл ажиллагааг өөрөө төлөвлөх гэсэн олон улсын чиг хандлага, онол, үзэл баримтлал зэрэгт тулгуурлан шинжлэх ухааны үндэслэлтэй өөрчлөлт шинэчлэлийг хийсэнтэй шууд холбоотой юм.

#### Хүснэгт 4. Багш боловсролын суурь хичээлийн харьцуулалт

№	Хичээлүүд	2014	2018	2021	Хичээлүүд	2014	2018	2021
	Заавал судлах хичээл				Сонгон судлах хичээл			
1	БМУ	1	1	1	Цахим Сургалтын АЗ	2	2	2
2	Ерөнхий сэтгэл судлал		2	2	Хөтөлбөр судлал	2	2	2
3	Хүний хөгжлийн с/судлал	2			Багшийн ёс зүй	1	1	2
4	Боловсролын сэтгэл судлал	4	3	3	Хүүхэд хамгаалал	1	1	2
5	Суралцахуй ба Б/үндэс	3	3	3	Сургууль судлал	1	1	2
6	Сургалтын онол арга зүй	2	3	3	Хүний хөгжлийн сэтгэл судлал	2	2	2
7	Боловсролын үндэс	1			Боловсролын хэмжил зүй		2	2
8	Судалгааны арга зүй	2	2		Боловсролын судалгааны арга зүй	2	2	
9	Сургуулийн бага насны хүүхдийн сэтгэл судлал	3			Судалгааны мэдээллийн автоматжуулалт			2
10	Бага боловсролын НАЗ	3						
11	Тэгш хамруулах Б/үндэс	2	2	2				
	Нийт судлах кредит	<b>24</b>	<b>16</b>	<b>14</b>	Нийт сонгон судлах кредит	<b>2</b>	<b>2</b>	<b>2</b>

2014 онд 24 кредит цагийн хичээл судалж байсан бол 2021 онд 14 кредит болгож өөрчлөлт оруулжээ. “Сургуулийн бага насны хүүхдийн сэтгэл судлал”, “Нэгдмэл

арга зүй” хичээлүүдийг мэргэжлийн заавал судлах хичээл рүү шилжүүлж кредитийн харьцаа 2018 онд 16 кр, 2021 онд 14 кр болгож өөрчлөлт орсон байна. Мөн боловсролын үндэс, хүний хөгжлийн сэтгэл судлал, судалгааны арга зүй зэрэг хичээл хасагдсан байна. Сонгон судлах хичээлээс оюутан 2 кредит сонгож судлахаар тусгасан байна. Сонгон судлах хичээл дээр кредит цагийг нэмэх хэрэгцээ шаардлага байгаа нь дээрх судалгаанаас харагдаж байна. Учир нь оюутнуудын эрэлт хэрэгцээ, нийгмийн чиг хандлага, олон улсын хөтөлбөрүүдийн жишиг загварыг харгалзах нь нэн чухал. Мөн түүнчлэн хичээлүүдийг олон хувилбартай багц сонголттой болгосноор тухайн оюутан илүү гүнзгийрүүлэн сонгон судлах боломж нэмэгдэж болох юм.

Хүснэгт 5 . Мэргэжлийн заавал судлах хичээл

№	Хичээлүүд	2003	2008	2011	2014	2018	2021
1	Орчин цагийн монгол хэл	7					
2	АШМОУ	8					
3	Зөв дуудах, зөв бичих зүй					2	2
4	Үгийн сан					2	2
5	Сургуулийн хэл зүй					3	3
6	Үндэсний бичиг, соёл					1	1
7	Аман зохиол					1	1
8	Олонлог логикийн элемент					2	2
9	Алгебр					2	2
10	Рационал тоо үйлдэл					2	2
11	Математик арга зүй удиртгал			21		2	2
12	Тоо тоолол арга зүй				3	3	3
13	Геометр ба хэмжигдэхүүн арга зүй				2	2	2
14	Өгөгдөлтэй ажиллах арга зүй				2	2	2
15	Өгүүлбэртэй бодлого бодох арга зүй					2	2
16	Хичээнгүй бичиг-2			27	2	2	2
17	Монгол хэлний арга зүй I				2	2	2
18	Монгол хэлний арга зүй II				2	2	2
19	Цагаан толгой арга зүй-2				2	2	2
20	Хүүхдийн уран зохиол-2				2	2	2
21	Хүн байгаль		3	3	3	3	3
22	Байгаль шинжлэл арга зүй				3	3	3
23	Эрүүл мэнд арга зүй					1	1
24	Иргэний боловсрол арга зүй					2	2
25	Технологи дидактик		3	3		3	3
26	Дүрслэх урлаг дидактик		3	3		3	3
27	Дуу хөгжим дидактик		3	3		2	2
28	Биеийн тамир дидактик		2	3		2	2
29	Мэдээлэл зүй дидактик		2	2			

30	Иргэний боловсрол, арга зүй			3	2	2	2
31	Хүн нийгэм		3		2	2	2
32	Сургуулийн бага насны хүүхдийн сэтгэл судлал					3	3
33	Бага боловсролын нэгдмэл арга зүй					3	3
34	Мэргэших хичээлийн удиртгал				2		
35	Хичээлээс гадуурх үйл ажиллагаа, арга зүй				2	1	1
36	Амьдрах чадварт суралцах үйл ажиллагаа				1		
37	Мэргэжлийн судалгааны арга зүй						2
3	Дипломын ажил бичих, төгсөлтийн шалгалт				2	2	2
Нийт		<b>15</b>	67	74	44	66	68

2000-2007 онд сургалтын төлөвлөгөөний бүтэц өөр байсан учир мэргэжлийн хичээлийг 2014 оны шинэчилсэн төлөвлөгөөтэй харьцуулалт хийх боломжгүй юм.

#### Хүснэгт 12 . Мэргэшүүлэх хичээлийн сонгон судлах хичээл

№	Хичээлүүд	2000	2003	2007	2008	2011	2014	2018	2021
1	Хүүхэд бүрийг хөгжүүлэх арга зүй							2	2
2	Сэтгэл заслын арга, зөвлөгөө				8	7		2	2
3	ББ-ын багшлахуйг дэмжих арга зүй							2	2
4	Эх задлах арга зүй		22	21				2	2
5	Утга судлал							2	2
6	Уншихуй ба жүжиглэхүй							2	2
7	Дэлхийн хүүхдийн уран зохиол							2	2
8	Магадлалын онол		22	21				2	2
9	Статистик							2	2
10	Танин мэдэхүй, туршилтын арга зүй							2	2
11	Орон нутгийн нийгэм, түүх соёл							2	2
12	Хүүхдийн дуу хөгжимдөх арга зүй	6	22	21	8	7	8	2	2
13	Бие бялдар- Хөдөлгөөний ур чадвар	6	22	21	8	7	8	2	2
14	Хэрэглээний төсөл хэрэгжүүлэх арга зүй							2	
15	Англи хэл	6	22	21	7	7			
16	Байгаль шинжлэл		22	21	7	7			
17	Зохион бүтээх хөдөлмөр		22		8		8		
18	Дүрслэх урлаг	6	22	21	8	7	8		
19	Түүх		22	21	7	7			
20	Мэдээлэл зүй заах арга				7	7			
21	СХ-х судалгааны АЗ	6							
22	Нийгмийн ажлын арга зүй	6							
Бүгд		14	22	21	15	14	8	4	4

2000-2013 оны хичээлийн жилд мэргэшүүлэх хичээлийн сонгон судлах хичээл нь 14-22 кредитийн судлах багтаамжтай байсан байна. Энэ нь нэг талаас оюутны тасралтгүй хөгжлийг дэмжсэн, багц байдлаар судлах боломжтой сайн хувилбар мөн байсныг онцлон хэлмээр байна. 2014 оноос мэргэшүүлэх хичээлийн сонгон судлах хичээлийн тоог нэмэгдүүлсэн боловч судлах кредитийг 4 байхаар хэм хэмжээг зааж өгчээ. 2011 оны төлөвлөгөөнд Технологи дидактик, Дүрслэх урлаг дидактик, Дуу хөгжим дидактик, Биеийн тамир дидактик хичээлүүд заавал судлахаар тусгагдаж байсан бол 2018, 2021 оны шинэчилсэн төлөвлөгөөнд мэргэжлийн заавал судлах хэсэгт оруулсан нь зөв шийдэл байсан юм. Учир нь Урлаг (хөгжим, дүрслэх урлаг, технологи), биеийн тамирын боловсролын агуулга нь бие бялдраа хөгжүүлэх, гоо сайхныг мэдрэх, шинийг санаачилж бүтээх, соёл өв уламжлалаа дээдлэх, ёс суртахуунтай байх мэдлэг ойлголт, хандлага төлөвшилтэй болоход энэхүү хичээлийн агуулга бага боловсролын багш бэлтгэх мэргэжлийн хичээлд заавал судлах ёстой хичээл. Цаашид сонгон судлах хичээлийн нэр төрлийг нэмэгдүүлэх, Технологи арга зүй, Дүрслэх урлаг арга зүй хичээлийн хүрээнд гүнзгийрүүлэн мэргэшүүлэх хичээлийг нэмж тусгах шаардлагатай гэдэг нь дээрх сонгон судлах хичээлийн төлөвлөгөөнөөс ажиглагдаж байна.

График 2. Багшлах дадлагын харьцуулалт (2011-2021)



2014 онд дадлагын нэр төрөлд өөрчлөлт орж оюутан бүх улиралд дадлага хийхээр тусгасан байна. Нийт 6 төрлийн дадлага нийт 14 кредит буюу 11,4%, 2018 онд 4 төрлийн дадлага буюу 10,3%-ийг дадлага эзэлж байна.

## Дүгнэлт

Бага боловсролын багш бэлтгэх сургалтын төлөвлөгөө 2014 оноос өмнө 134-137 кредит цагийн багтаамжаар судалдаг байсан бол 2014-2021 оны үед 124-126 кредитийн багтаамжтай сургалтын үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж байна. Бид нэн түрүүнд хүүхэд залуучуудын хүлээлт, хэрэгцээ, тулгарч буй бэрхшээлийг ойлгох хэрэгтэй. Бакалаврын сургалтын төлөвлөгөөнд хүүхэд залуучууд, бага боловсролын багшийн эрэлт хэрэгцээнд нийцсэн хичээлүүдийн агуулгыг түлхүү

оруулах нь зүйтэй. Тухайлбал, Ангийн менежмент, Бага ангийн хүүхдийн суралцахуйн сэтгэл судлал, Тоглонгоо суралцах арга зүй, Контент бэлтгэх арга зүй, Мэргэжлийн хөгжил, Багшийн манлайлал, Байгууллагын сэтгэл зүй, зэрэг бага ангийн багшид шаардлагатай хичээлүүдийг төлөвлөж оруулах хэрэгцээ байгаа нь дээрх судалгааны үр дүнгүүдээс тодорхой харагдаж байна.

Багш боловсролын суурь хичээлийн сонгон судлах хичээлүүдэд зохих өөрчлөлт оруулах

Учир нь бага болон дунд ангид багшлах нь онцлог ялгаатай тул зөвхөн E кодтой сонгон судлах хичээлүүдийг бус, бага боловсрол руу чиглэсэн, бага боловсролын агуулга, арга зүйд нийцсэн хөтөлбөр дэвшүүлэх хэрэгцээ үүсэж байна.

Мэргэжлийн хичээл болон сонгон мэргэших хичээлүүдийн нэр нэршилд өөрчлөлт хийх, шинэчлэн сайжруулах хэрэгцээ байсаар байна.

## Ном зүй

МУБИС. (2015). Сургалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх журам, гэрээ, маягтууд.

Бурмаа., Ц (2013) Багш бэлтгэх хөтөлбөрийн олон улсын чиг хандлага, туршлагын харьцуулсан судалгааны тайлан.

Энхээ, Д., Энхцэцэг, Д (2011). Бага боловсролын багш мэргэжлийн бакалаврын боловсрол эзэмшигчдэд тавих стандартын шаардлагын төсөл боловсруулах судалгааны нэгдсэн тайлан. Улаанбаатар.

Тамир, Х., & Бурмаа, Ц. (2015). Багш боловсролын хөтөлбөрийн шинэчлэл. Боловсролын судалгаа-Инновацийн хөгжил (pp.19-24). УБ:МУБИС, хэвлэлийн цех.

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Багшийн сургуулийн “Бага ангийн багш” бэлтгэх хөтөлбөр. (2000-2021)

Вэсли Нулл (2011). Багш боловсролын сайн хөтөлбөр боловсруулахын тулд бид юу хийх ёстой вэ? Киррикилум (хөтөлбөр). Онолоос практикт. Улаанбаатар.

бэлтгэх сургалтын төлөвлөгөөний олон улсын харьцуулалт. Оюуны хөтөч, 52-54.

Жаргалсайхан, П., Түмэнцэцэг, Б., (2017). Монгол, Солонгос Улсын Бага боловсролын багш бэлтгэх сургалтын төлөвлөгөөнүүдэд хийсэн харьцуулалт. Бага боловсролын асуудал шийдэл. Олон Улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. 178-181

**COMPARISON, MODIFICATION AND INNOVATION OF  
CURRICULUM PREPARED BY PRIMARY EDUCATION TEACHERS  
(Study Plan for 2000-2021)**

<sup>a</sup>Byambatogtokh G, <sup>b</sup>Tamir Ts  
<sup>a</sup>Teachers School, MNUE;  
<sup>b</sup>Teachers School, MNUE

Corresponding author: Byambatogtokh@msue.edu.mn 

**Abstract**

Over the past 20 years, there has been rapid development in information and communication technology, a dramatic increase in the public demand for education and training, and swift changes in education due to the transition to a market economy. This evolution has prompted a radical transformation in educational approaches, shifting from simple content acquisition to more meaningful, skill-based learning experiences. Teacher education institutions are responding to these changes by focusing on improving their curricula, standards, and teaching methods to align with technological advances and the needs of an evolving society. Our primary objective was to analyze how the primary education teacher training curriculum has changed and been reformed over the past two decades.

A significant structural change occurred in the requirements for primary education teacher training. Prior to 2014, the program required 134-137 credit hours. However, during the period of 2014-2021, this was streamlined to 124-126 credits. The curriculum needs further development to meet the needs of Generation Alpha—the two billion children who will be studying worldwide by 2025.

**Keywords**

General background, faculty, specialty courses, internships, credit hours, comparisons.